

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНААР 2016 ОНД  
ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА**

/2016 оны жилийн эцсийн байдлаар/

2016.12.28

**Нэг. Танилцуулга**

ЗТХЯ нь 2016 онд Засгийн газрын хуралдаанаар нийт 40 асуудал хэлэлцүүлэхээр төлөвлөж, саналаа ЗГХЭГ-т хүргүүлэн ТНБД-ын 2015.03.07-ны өдрийн 75 дүгээр тушаалаар батлуулсан байна.

2016 оны төлөвлөгөөнд ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тусгагдсан асуудлын тоог газар, хэлтсээр нь авч үзвэл (давхардсан тоогоор):

№	Хариуцах газар, хэлтэс	Улирал				Нийт	
		I	II	III	IV	нийт	Үүнээс толгойлон
1	БТГ	7	5	3	-	15	6
2	ТЗУГ	4	1	-	1	6	-
3	ТЗДТБХЗГ	3	9	-	1	13	12
4	АЗБХЗГ	5	1	1	-	7	5
5	АТБХЗГ	3	-	1	-	4	3
6	АТБХЗХ	3	6	2	-	11	11
7	ХШҮДАГ	1	2	-	-	3	3
<b>Нийт</b>		<b>17</b>	<b>18</b>	<b>4</b>	<b>2</b>	<b>40</b>	

Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөсөн 40 асуудлын хэрэгжилтийг 2016 оны жилийн эцсийн байдлаар газар, хэлтсүүдээр авч үзвэл:

№	Газрын нэр	Төлөвлөсөн	Хэлэлцүүлсэн	Хасагдсан	Биелээгүй						Хувь*
					90%	70%	50%	30%	10%	0%	
1	БТГ	15	9	1	-	1	3	1	-	-	64,3 /82,1/
2	ТЗУГ	6	2	-	-	1	2	1	-	-	33,3 /66,7/
3	ТЗДТБХЗГ	13	2	1	1	4	3	1	-	1	16,6 /62,5/
4	АЗБХЗГ	7	7	-	-	-	-	-	-	-	100,0 /100,0/
5	АТБХЗГ	4	1	-	1	-	2	-	-	-	25,0 /72,5/
6	АТБХЗХ	11	3	1	3	5	-	-	-	-	30,0 /85,0/
7	ХШҮДАГ	3	-	2	1	-	-	-	-	-	0,0 /90,0/
<b>Нийт</b>		<b>40</b>	<b>15</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>9</b>	<b>5</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>41,7 /79,4/</b>

\*Хаалтанд байгаа хэрэгжилтийн хувь нь хэрэгжилтийн явцын байдал, хаалтын өмнөх хувь нь асуудлыг шийдвэрлэсэн эсэхээр гаргасан хувь. Төлөвлөгөөний биелэлтийг Засгийн газраас үнэлэхдээ Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлсэн бол 100%, хэлэлцүүлээгүй бол явц нь ямар байгааг харгалзахгүйгээр 0% гэж үнэлдэг.

## Хоёр. Үнэлэлт, дүгнэлт

### 1. Төлөвлөлтийн байдал:

1) 2015 оны төлөвлөгөөнд тусгаад хэлэлцүүлээгүй үлдсэн 20 асуудлаас 2016 оны төлөвлөгөөнд 16 асуудлыг тусгаж, 4 асуудлыг тусгаагүй хассан бөгөөд эдгээр нь төлөвлөгөөнд тусгах шаардлагагүй асуудлууд байна.

2) Зам, тээврийн салбарын 6 хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлэлцүүлэхээр төлөвлөсөн боловч 5-д нь БТГ-ыг хариуцан хэрэгжүүлэх нэгжид оруулаагүй байна.

3) ЗТЯ-ны ТНБД-ын 2012.11.06-ны өдрийн 104 дүгээр тушаалаар батлагдсан “Зам, тээврийн яамны албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны журам”-ын дагуу Яамны газар/хэлтэс/ нь ажил үүргийнхээ хуваарьт хамаарах ЗГ-ын хуралдаанаар тухайн жилд хэлэлцүүлэх асуудлыг төлөвлөж, хэлэлцүүлэх асуудлын жагсаалтыг тухайн оны 1 дүгээр сард багтаан батлуулах ёстой. Гэвч 2016 оны төлөвлөгөөг 3 сарын 7-ны өдөр батлуулсан байна.

4) Салбарын 3 хуулийн төслийг ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлэх ажлыг ЗТЯ-ны үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөөнд 1-6 сард хийхээр төлөвлөсөн боловч ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөнд I улиралд хэлэлцүүлэхээр төлөвлөсөн байна. Энэ нь яамны хэмжээнд төлөвлөлтийн уялдаа холбоо муу, газар хоорондын хамтын ажиллагаа сул байгааг харуулж байна.

### 2. Хэрэгжилтийн байдал:

1) 2016 онд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөсөн 40 асуудлаас 15 асуудал хэлэлцүүлж, 5 асуудал хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлсэн, 4 асуудал хэлэлцүүлэх шаардлагагүй болсон, 9 асуудал 70%, 5 асуудал 50%, 1 асуудал 30%-ийн хэрэгжилттэй, 1 асуудал албан хүсэлт ирээгүй тул хийгдсэн ажилгүй, төлөвлөгөөний биелэлт 41,7%, хэрэгжилтийн явц 79,4%-тай байгаа нь маш хангалтгүй байна.

2) Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барихаар дэмжигдсэн, хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлсэн болон Засгийн газрын гишүүдээс санал авсан байсан 12 асуудал Засгийн газрын бүтцийн өөрчлөлтэй холбогдон буцаагдсан нь төлөвлөгөөний хэрэгжилтийн явц муу гарахад нөлөөлсөн байна.

3) Энэ онд хэлэлцүүлэхээр төлөвлөсөн 6 хуулийн төслөөс Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцүүлсэн боловч Засгийн газар шинээр байгуулагдсантай холбогдон буцаагдсан. Иргэний нисэхийн тухай, Авто тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг шинэчлэн батлуулсан, Усан замын тээврийн болон Далай ашиглах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулаад байна.

4) Шивээхүрэн боомтоос Улсын урд хил хүртэлх чиглэлийн төмөр замын зурвас газрын хэмжээ, хугацаа, нөхцлийг тогтоох тухай асуудал холбогдох байгууллагаас албан хүсэлт ирүүлээгүй тул хийгдсэн ажилгүй байна.

5) Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежментийн концессын гэрээ байгуулах, Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Далай ашиглах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Дугуйт тээврийн хэрэгсэлд ашиглах, тоноглох эд анги, тоног төхөөрөмж болон дугуйт тээврийн хэрэгслийн нэгдсэн зааврыг батлах, эдгээр зааврыг үндэслэн олгогдсон зөвшөөрлийг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцлийн талаарх 1958 оны Олон улсын гэрээнд нэгдэн орох, Олон улсын Далайн байгууллагын “Гадаад

далайг газрын тосоор бохирдуулахад хүргэсэн далай, тэнгисийн осол зөрчил гарсан тохиолдолд хөндлөнгөөс оролцох тухай” 1969 оны конвенц, түүний хавсралтад нэгдэн орох, “Төмөр замын олон улсын шууд харилцааны тухай Конвенци”-д нэгдэн орох, Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр зам, “Болд төмөр ерөө гол” ХХК-ийн төмөр замын зурвас газрын хэмжээ, хугацаа, нөхцөлийг тогтоох асуудлууд удаашралтай явж байна.

### **Гурав. Санал, зөвлөмж**

1) Цаашид ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг тухайн оны 1 дүгээр сард багтаан батлуулж хэвших;

2) ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг яамны бусад төлөвлөгөөтэй нягт уялдуулан хэрэгжих боломжтой хугацаанд, хэлэлцүүлэх шаардлагатай асуудлыг бүрэн хамруулж төлөвлөж байх;

3) 2016 оны төлөвлөгөөнд тусгагдсан боловч хэрэгжээгүй ажлуудыг 2017 оны Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөнд тусгуулах, яаралтай хэрэгжүүлэх талаар газар, хэлтсийн дарга нар онцгой анхаарч ажиллах;

4) Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг газар, хэлтсийн дарга нар тухайн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн Үр дүнгийн гэрээг дүгнэх шалгуур үзүүлэлтүүдийн нэг болгож ажиллах;

Танилцсан:

Төрийн нарийн бичгийн дарга

Ж.Бат-Эрдэнэ

Хянасан:

ХШҮДАГ-ын дарга

Т.Гомбосүрэн

Боловсруулсан:

ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн

Д.Баярмаа